



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/649

Хэрлэн сум

Газар өмчлөх эрхийг дуусгавар болгож газар эзэмших эрхийн төрөл рүү шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар өмчлөх эрхээ газар эзэмших эрх рүү шилжүүлэх хүсэлтийн дагуу Оюунтуяагийн Амгаланбаяр (СЦ83031616)-ын Хэрлэн сум 2 дугаар баг Булаг баатрууд м 20 гудамж 04 тоот, 503 м2 газрыг газар өмчлөх эрхийг дуусгавар болгож гэр бүлийн хэрэгцээний газар эзэмших эрх рүү 60 жилээр шилжүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/621 дүгээр захирамжийн дээрх иргэнд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Газар өмчлөх эрхийг дуусгавар болгож, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ